



АРХИВЫН
ЕРӨНХИЙ
ГАЗАР



МОНГОЛЫН
ҮНДЭСНИЙ
МУЗЕЙ



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ
НОМЫН САН



ТҮҮХ
УГСААТНЫ
ЗҮЙН ХҮРЭЭЛЭН

"ДЭЛХИЙД ТАРХСАН МОНГОЛ ӨВ: АРХИВЫН БАРИМТ, БИЧГИЙН ДУРСГАЛ" ҮЗЭСГЭЛЭН

EXHIBITION FOR "MONGOLIAN HERITAGE SPREAD AROUND THE WORLD: ARCHIVAL DOCUMENTS AND WRITTEN MONUMENTS"

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУД:



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ



ГАДААД ХАРИЛЦААНЫ
ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ ЯАМ



СОЁЛЫН ЯАМ

УЛААНБААТАР ХОТ
2021 ОНЫ 06 ДУГААР САРЫН 21-25



АРХИВЫН
ЕРӨНХИЙ
ГАЗАР



МОНГОЛЫН
ҮНДЭСНИЙ
МУЗЕЙ



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ
НОМЫН САН



ТҮҮХ
УГСААТНЫ
ЗҮЙН ХҮРЭЭЛЭН

**"ДЭЛХИЙД ТАРХСАН
МОНГОЛ ӨВ:
АРХИВЫН БАРИМТ,
БИЧГИЙН ДУРСГАЛ"
ҮЗЭСГЭЛЭН**

**EXHIBITION FOR
"MONGOLIAN HERITAGE
SPREAD AROUND THE
WORLD: ARCHIVAL
DOCUMENTS AND WRITTEN
MONUMENTS"**



ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУД:



хууль зүй,
дотоод
хэргийн яам



ГАДААД
ХАРИЛЦААНЫ
ЯАМ



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ
УХААНЫ ЯАМ



СОЁЛЫН ЯАМ

**УЛААНБААТАР
2021**

ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУД:



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ АРХИВЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ
УХААНЫ АКАДЕМИ



ОЛОН УЛСЫН МОНГОЛ
СУДЛАЛЫН ХОЛБОО



ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ



ГАДААД
ХАРИЛЦААНЫ
ЯАМ




БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ
УХААНЫ ЯАМ



СОЁЛЫН ЯАМ

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



**"ДЭЛХИЙД ТАРХСАН
МОНГОЛ ӨВ:
АРХИВЫН БАРИМТ,
БИЧГИЙН ДУРСГАЛ"**

**ОЛОН УЛСЫН ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ, ҮЗЭСГЭЛЭН**

МОНГОЛ УЛС

**УЛААНБААТАР
2021**



Гадаад оронд хэвлэгдсэн Монголын түүх, соёлд холбогдох баримтын катологууд

"ДЭЛХИЙД ТАРХСАН МОНГОЛ ӨВ:
АРХИВЫН БАРИМТ, БИЧГИЙН ДУРСГАЛ"
ҮЗЭСГЭЛЭН

Үзэсгэлэнгийн зөвлөх:

Академик С.Чулуун

Олон улсын монгол судлалын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга

Үзэсгэлэнг зохион байгуулах ажлын хэсгийн гишүүд:

Б.Ринчинноров

Архивын ерөнхий газрын Эрдэм шинжилгээний ахлах ажилтан

П.Чүлтэмсүрэн

Архивын ерөнхий газрын Эрдэм шинжилгээний ажилтан

Г.Сэр-Од

Архивын ерөнхий газрын Эрдэм шинжилгээний ажилтан

Э.Хүрэлбаатар

Архивын ерөнхий газрын Эрдэм шинжилгээний ажилтан

Ё.Батхшиг

Архивын ерөнхий газрын Хэвлэлийн дизайнер

Д.Бат-Ундрах

Үндэсний төв архивын Кино, гэрэл зураг, дуу авианы баримтын архивын Дүрс бичлэгийн инженер

Н.Туяа

Монголын Үндэсний музейн Куратор, сан хөмрөгч

Э.Оюунтуяа

Монголын Үндэсний музейн Бүртгэл мэдээллийн санч

Б.Нямдорж

Монголын Улсын Үндэсний номын сангийн Гадаад харилцааны мэргэжилтэн

Ч.Гансүх

Монголын Улсын Үндэсний номын сангийн Сан хөмрөгч

Б.Отгонтуяа

Монголын Улсын Үндэсний номын сангийн Сан хөмрөгч

Б.Нацагдорж

Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Сурвалж судлал, баримт мэдээллийн төвийн эрхлэгч, доктор (Ph.D)


Г.Баттушиг

Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан




"ДЭЛХИЙД ТАРХСАН МОНГОЛ ӨВ: АРХИВЫН БАРИМТ, БИЧГИЙН ДУРСГАЛ"


ӨМНӨХ ҮГ




Х.Чойбалсанд зориулсан хүндэтгэлийн зоог дээр И.В.Сталины хэлсэн үг. 1945.07.07 МУУТА. ТБА. Х.445. Х.2. ХН.62. Т.2.



Х.Чойбалсанг ЗСБНХУ-д эмчлүүлэхээр ирэхийг зөвшөөрөх тухай БХКБН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны хуралдааны 58 дүгээр протоколос. 1947.05.24 МУУТА. ТБА. Х.445. Д.6. ХН.26. Т.1.



БНМАУ-ын Засгийн газарт зээл олгох болон хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгийг байгуулах хэлэлцээрүүдэд гарын үсэг зурах тухай БХКБН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны хуралдааны 69 дүгээр протокол. 1949.05.19 МУУТА. ТБА. Х.445. Д.5. ХН.103. Т.2-3.



БНМАУ-ын Ерөнхий сайдын тушаалд нэр дэвшүүлэх боломжтой хүмүүсийн тухай А.А.Громыкогос И.В.Сталинд ирүүлсэн бичиг, тэдний товч намтар. 1952 он. МУУТА. ТБА. Х.445. Х.5. ХН.111. Т.7-11.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын санаачилгаар Монгол Улсын түүх, соёлд холбогдох гадаад улсад хадгалагдаж байгаа баримтыг нээн илрүүлэх, эх нутагт нь байршуулах, эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яам, Архивын ерөнхий газар, Шинжлэх ухааны академи, Олон улсын Монгол судлалын холбоо, Шинжлэх ухааны академийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Монгол Улсын Үндэсний номын сан, Монголын Үндэсний музей хамтран "Дэлхийд тархсан монгол өв: архивын баримт, бичгийн дурсгал" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэнг Улаанбаатар хотноо зохион байгуулж байна.

Энэхүү Олон улсын эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн нь хилийн чандад хадгалагдан буй монголын түүх, соёлд холбогдох дурсгалуудыг нээн илрүүлж, хуулбарлан авах, Үндэсний архивын сан хөмрөгийг баяжуулах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ юм.

Нэг эрдэм шинжилгээний хуралд 8 орны 27 эрдэмтэн судлаач оролцож Монгол, Орос, Унгар, Хятад, Польш, Англи, Франц, Япон, Солонгос, Турк, Вьетнам зэрэг улсын Үндэсний архив болон Үндэсний номын сангуудад хадгалагдаж буй монголын түүх, соёлд холбогдох баримтуудын талаарх судалгааны шинэ мэдээ, мэдээллийг хэлэлцүүлнэ. Тухайлбал: "ОХУ-ын Эртний Улсын архив дахь Монголын холбоотой баримт", "Унгараас монголд ирсэн хүмүүсийн тэмдэглэл", "Лхасын 800 монгол захидал: Монгол, Төвөдийн харилцааны шинэ баримтууд", "БНХАУ-ын нутаг дээрх хад чулуун дээр бичигдсэн монгол дөрвөлжин үсгийн дурсгалуудын тухай", "В.И.Лениний нэрэмжит Улсын номын санд хадгалагдаж буй монгол гар бичмэлийн тухай" зэрэг Монгол Улсын түүх, соёлд холбогдох баримтын талаар илтгэл хэлэлцүүлж, Үндэсний архивын сан хөмрөгийг баяжуулах асуудлаар санал солилцох юм.

Хоёр. Хамтарсан үзэсгэлэнд гадаад орноос хуулбарлан авч ирсэн Монгол Улсын түүх, соёлд холбогдох баримтыг дэлгэн байршуулна. Тухайлбал:

Тайваньд хадгалагдаж буй Эзэн Богд Чингис хаан болон Хубилай сэцэн хааны хөрөг, Хятад улсад хадгалагдаж буй Их Монгол Улсын нэр үл мэдэгдэгч зохиогчийн нангиад ханзаар галигласан "Монголын нууц товчоо", "Чанчун бумбын Баруун этгээдэд зорчсон тэмдэглэл", "Монгол татаарын бүрэн тэмдэглэл", Франц улсад хадгалагдаж буй "Өлзийт хаанаас Францын хаан Гоо Филиппт илгээсэн захидал", "Ромын пап ламаас Монголын хаанд илгээсэн захидал", "Монголын Ил хаан Аргунаас Францын хаан Филиппт илгээсэн захидал" болон Америк улсаас хуулбарлан авсан "Хятадын цэрэг Монгол руу хөдөлсөн тухай Харбин дахь АНУ-ын консул Листер Майнардаас АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргад илгээсэн цахилгаан мэдээ", Гадаад Монголын улс төрийн байдал болон Хятадын удирдагчдын уулзалтын талаарх "The Peking leader" сонин хайчилбарууд, Орос улсаас хуулбарлан авсан "Монгол дахь улс төрийн нөхцөл байдлын тухай Ф.Д.Финчиногос ОК(б)Н-ын Төв Хорооны Сибирийн товчоонд танилцуулсан илтгэл", Монгол дахь лам нарын байдлын тухай Виталийгийн илтгэл" зэрэг монголын түүхийн хосгүй үнэт өв болох бичгийн дурсгалууд болон архивын баримтыг дээжлэн байршуулж, олон нийтийн хүртээл болгохоор анх удаа дэлгэх юм.

Олон улсын эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэнг зохион байгуулахад гүн туслалцаа үзүүлж хамтран ажилласан Монгол Улсын Шинжлэх ухааны академи, Олон Улсын Монгол Судлалын Холбоо, Шинжлэх ухааны академийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Монголын Улсын үндэсний номын сан, Монголын Үндэсний музейн хамт олон болон олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэлээ хэлэлцүүлсэн эрдэмтэн судлаачдад талархлаа илэрхийлж байна.


Архивын ерөнхий газрын дарга/С.Энхбаатар/

"ДЭЛХИЙД ТАРХСАН МОНГОЛ ӨВ: АРХИВЫН БАРИМТ, БИЧГИЙН ДУРСГАЛ"




"ИХ ЭЗЭН БОГД ЧИНГИС ХААНЫ ХӨРӨГ"
Тайваний Үндэсний ордон музейд хадгалагдаж буй.

"ДЭЛХИЙД ТАРХСАН МОНГОЛ ӨВ: АРХИВЫН БАРИМТ, БИЧГИЙН ДУРСГАЛ"



Монголын тусгаар тогтнолын үндсэн нөхцлүүдийн тухай И.В.Сталинаас П.Гандэнд бичсэн захидал. 1934.03.07. МУУТА, ТБА, Х-445, Д-7, ХН-27, Х.1-4




ЗСБНХУ-ын Засгийн газрын удирдлагуудтай хийх уулзалтын үеэр БНМАУ-ын Ерөнхий сайд, Улсын шалгарсан маршал Х.Чойбалсангийн тавих асуултын жагсаалт. 1939. 12.07. МУУТА, ТБА, Х-445, Д-2, ХН-58, Х.1-4

АРХИВЫН БАРИМТ, БИЧГИЙН ДУРСГАЛ





"ЧИНГИСИЙН ЧУЛУУНЫ БИЧИГ"

Чингис хааны дүү Хавт Хасарын хүү Есүнгэ мэргэн 335алд газар харвасны дурсгалд зориулж 1225 онд босгосон гэрэлт хөшөө.
Боржин чулуун дээр 21 үгийг таван мөрөөр, монгол бичгээр бичжээ. Хөшөөний өндөр нь 202 см, өргөн нь 74 см, зузаан нь 22см.
1802 онд Хархираа, Үрлүнгүй голын бэлчирт орших Хондуйн балгаснаас нэгэн бичигт хөшөө олдсоныг нутгийн хэлмэрч нар эхний мөр тэтгэн бичсэн хоёр үгийг Чингис хаан хэмээн уншсанаар Чингисийн чулууны бичиг хэмээн алдаршжээ.




"МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО"

Их Монгол Улсын нэр нь үл мэдэгдэх зохиогчийн бүтээл. Чин улсын Төр гэрэлт хааны 27-р онд (1847) Лин Ши Ян Хүрээлэнгийн номын санд хадгалж байсан нангиад ханзаар галигласан хувилбар юм.
Монголын нууц товчоо бол Чингис хаанаас өмнөх 22 үеийн өвөг дээдсээс эхэлж, 1240 он хүртэлх үйл явдлыг багтаасан түүхэн эх сурвалж болно.




А. Я. Вышинскийгээс А.А.Андреевт БНМАУ-ын Үндсэн хуулийн төслийн тухай зурвас. 1939 он. МУУТА, ТБА, Х-445, Д-2, ХН-59, Х.129




БНМАУ-ын үндэсний бичгийг халж, орос үсэгт шилжүүлэх тухай МАХН-ын Төв Хорооны сургагч Д.И.Сидоровын бичиг. 1941.04.26 МУУТА, ТБА, Х.445. Х.5. ХН.88. Т.1.

"ДЭЛХИЙД ТАРХСАН МОНГОЛ ӨВ: АРХИВЫН БАРИМТ, БИЧГИЙН ДУРСГАЛ"

"ДЭЛХИЙД ТАРХСАН МОНГОЛ ӨВ: АРХИВЫН БАРИМТ, БИЧГИЙН ДУРСГАЛ"




Монгол дахь улс төрийн нөхцөл байдлын тухай Э.Д.Ринчиногоос ОК(б)Н-ын Төв Хорооны Сибирийн товчоонд танилцуулсан илтгэл. 1920.09.01. МУУТА, ТБА, Х-445, Д-5, ХН-6, Х-1-16




Монгол дахь Барон Унгерн болон Хятад цэргийн байлдааны ажиллагааны тухай ОК(б)Н-ын Төв Хорооны Сибирийн товчооны Дорно дахины ард түмний секцийн Монгол-Түвэдийн хэлтэст Гочитскийн ирүүлсэн захидал. 1920.11.29. МУУТА, ТБА, Х-445, Д-1, ХН-12, Х-5




"ХУБИЛАЙ СЭЦЭН ХААНЫ ХӨРӨГ"
Тайванийн Үндэсний ордон музейд хадгалагдаж буй.



Г.В.Чичеринээс ОК(б)Н-ын төв Хорооно Унгерний дээрэмчдийг устгахын тулд Монголд ЗСБНХОУ-ын ба АДБНУ-ын цэргийн аян хийх тухай асуудлаар Хятадын Засгийн газартай хэлэлцээр хийх талаар илгээсэн бичиг. 1921.06.13. МУУТА, ТБА, Х-445, Д-6, ХН-2, Х-1-2




Коминтерний АДНБДНГ-ыг байгуулснаас хойш Монголд явуулсан улс төр, цэргийн ажлын үр дүнгийн тухай Б.Я.Шумяцкийгаас Г.В. Чичеринд бичсэн захидал. 1921.08.12. МУУТА, ТБА, Х-445, Д-1, ХН-15, Х-2-6




"БИЕЭР ДАЙЛСАН ТЭМДЭГЛЭЛ"

Дай Юан Улсын үеийн нэр нь тодорхойгүй зохиогчийн бүтээл. Дай Чин улсын Хү Чү Таогийн засаж найруулсан хэвлэлийн хуулбар хувь. Энэ бүтээлд Дай Юан Улсын Тайзу Чингис хаан мэндэлснээс (1162) эхлэн Тайзун Өгэдэй хаан таалал төгссөн (1241) хүртэлх түүхэн үйл явдлыг бичсэн байдаг.




Богд гэзгэн таалал төгссөн хийгээд энэ үйл явдлуудын тухай Монгол дахь ЗСБНХУ-ын Бүрэн эрхт төлөөлөгчдийн газрын мэдээлэл сэтгүүл. Дугаар №10. 1924.05 сар. МУУТА, ТБА, Х-445, Д-7, ХН-5, Х-1-38



Монголд улс төрийн бодлого өөрчлөгдөж байгаа тухай И.В.Сталинаас К.Е.Ворошиловт бичсэн захидал. 1932.06.12. МУУТА, ТБА, Х-445, Д-2, ХН-27, Х-3


"ӨРНӨ ЭТГЭЭДЭД ЗОРЧСОН ТЭМДЭГЛЭЛ"

Дай Юан Улсын үеийн бүтээл. Эртний хуулбар хувь. Элчин сайд Чан Дү гэгч зарлигаар өрнө зүгт элчлэн одоход бараа болгох Лү Үй гэгч бичсэн аян замын тэмдэглэл юм. Уг бүтээлд Мөнх хааны 9-р онд (1259) Чан Дү бээр зарлигийг хүлээн өрнө зүгт одож, Сартууд сууж асан Ил хаан Хүлэгүгийн ордод хүрэх явцад аян замын турш үзэж сонссон бүхнийг тэмдэглэн бичсэн байдаг.





西使記

"ДЭЛХИЙД ТАРХСАН МОНГОЛ ӨВ: АРХИВЫН БАРИМТ, БИЧГИЙН ДУРСГАЛ"





"ГҮЮГ ХААНЫ ЗАХИДАЛ"
Гүюг хаанаас Ромын пап ламд илгээсэн захидлын хуулбар. 1246 он. Хэмжээ: Урт:120см.



"ХУБИЛАЙ ХААНЫ ЗАХИДАЛ"



Их Монгол Улсын Хубилай хааны Японы эзэн хаанд илгээсэн захидлын хуулбар. 1266 он.
Японы Буддын шашны Тожи сүмийн хамбын бэлэглэсэн эх хувийн хуулбар. Урт: 116см, Өндөр: 75см.



"РОМЫН ПАП ЛАМЫН ЗАХИДАЛ"


Ромын пап ламаас Монголын хаанд илгээсэн захидлын хуулбар. 1245 он.
Хэмжээ: Урт: 35см, Өндөр: 25см

"ДЭЛХИЙД ТАРХСАН МОНГОЛ ӨВ: АРХИВЫН БАРИМТ, БИЧГИЙН ДУРСГАЛ"



Монголын талаар Хятад, Орос улсын хэлэлцсэн тунхаглал. 1913 он.
МУУТА, ТБА, Х-445, Д-12, ХН-3

Гадаад Монголын тусгаар тогтнолыг Семёнов өдөөн хатгаж бослого хөдөлгөөнд уриалсан тухай ДИУ-ын ГЯЯ-нд мэдэгдсэн бичиг. 1919.06.16.
МУУТА, ТБА, Х-445, Д-12, ХН-6




Монголын хил хязгаар, нутаг дэвсгэрийн зураг. 1919 он.
МУУТА, ТБА, Х-445, Д-12, ХН-8



Гадаад Монголын тусгаар тогтнолд Япон улс халдаж буй талаар бичсэн нийтлэл. 1936.03.06.
МУУТА, ТБА, Х-445, Д-12, ХН-36



Түшээт хан аймгийн харуул болон Хаант Орос улсын хилийн зааг зураг.
МУУТА, ТБА, Х-445, Д-12, ХН-194




Монголын газар нутаг, засаг захиргааны бүтэц хүн ам болон газрын зураг.
МУУТА, ТБА, Х-445, Д-12, ХН-199




Монголын хойд хил хязгаарын зураг.
МУУТА, ТБА, Х-445, Д-12, ХН-200

"ДЭЛХИЙД ТАРХСАН МОНГОЛ ӨВ: АРХИВЫН БАРИМТ, БИЧГИЙН ДҮРСГАЛ"

"ДЭЛХИЙД ТАРХСАН МОНГОЛ ӨВ: АРХИВЫН БАРИМТ, БИЧГИЙН ДҮРСГАЛ"



Монгол болон Оросууд Лу Пянь Фу руу дайрсан тухай Америкийн консул Листер Майнардаас АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргад илгээсэн цахилгаан мэдээ. 1912.02.06. МУУТА, ТБА, Х-445, Д-13, ХН-3




Монгол болон Хятадын Засгийн газрын хооронд гарсан мөргөлдөөний тухай АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Фиширээс Бээжин дэх АНУ-ын Бүрэн эрхт сайд В.Ц.Галхаунд ирүүлсэн цахилгаан мэдээ. 1912.08.21. МУУТА, ТБА, Х-445, Д-13, ХН-9




"АРГУН ХААНЫ ЗАХИДАЛ"

Ил хаан Аргунаас Францын хаан Гoo Филиппт илгээсэн захидлын хуулбар. 1289 он. Урт: 182 см, Өндөр: 39 см.



Мүгдэн дэх улс төрийн байдал ба Орос Монголын гэрээ. 1912.11.30. МУУТА, ТБА, Х-445, Д-13, ХН-18




Хаант Монгол Улсын ноёд, түшмэдээс АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргад илгээсэн өргөх бичиг. 1920.09.09. МУУТА, ТБА, Х-445, Д-13, ХН-32




"ГАЗАН ХААНЫ ЗАХИДАЛ"


Ил Хаан Газанаас Ромын пап Бонифаст VIII илгээсэн захидлын хуулбар. 1302 он. Урт: 98см, Өндөр: 45см.



Монголын Засгийн газрын талаарх мэдэгдэл, Өргөө болон Монголын улс төрийн байдал, Оросын нөлөөний талаарх орос, англи хэл дээрх мэдээнүүд. 1921.08.13-11.23. МУУТА, ТБА, Х-445, Д-13, ХН-55




Монголын талаарх А.Ф.Осендовскийн нууц меморандум. /орос гар бичмэл, англи орчуулга/. 1921.11.28. МУУТА, ТБА, Х-445, Д-13, ХН-61



"ӨЛЗИЙТ ХААНЫ ЗАХИДАЛ"

Ил Хаан Өлзийтөөс Францын хаан Гoo Филиппт илгээсэн захидлын хуулбар. 1304 он. Хэмжээ: Урт: 60.5см, Өндөр:39.3см, Урт: 60.5см, Өндөр:15см.

"ДЭЛХИЙД ТАРХСАН МОНГОЛ ӨВ: АРХИВЫН БАРИМТ, БИЧГИЙН ДУРСГАЛ"




АРАГ ВАНГИЙН
ЛИНЖЬ БИЧИГ
(1340 он)
Юннан мужийн Күнмин хотод
Юан Улсын луу жилийн 4 сард
босгосон хөшөөний бэхээр
дарсан хувь.
128.2 x 120.7см




МОГАОКУГИЙН СУЛЕЙМАН ХААНЫ
АЛДРЫГ МОНХЖҮҮЛЭХ БЭЙТАШ

Хөшөөний төвд Хоншим Бодьсад бурхны хөрөг дээр нь самгарьд, төвд хэлээр, зүүн талд тангууд, нангиадаар, баруун талд дөрвөлжин болон монгол бичгээр Ум Мани Бадмэ Хум гэж бичжээ.


"ДЭЛХИЙД ТАРХСАН МОНГОЛ ӨВ: АРХИВЫН БАРИМТ, БИЧГИЙН ДУРСГАЛ"



МОНГОЛОР АЛТНЫ УУРХАЙН ФОТО АЛЬБОМ. ЭХ
42 хуудас, 83 фото зураг бүхий цомог.



ТӨВ АЗИ БА АЛТАН ХАРУУЛААР
ЯВСАН ЭКСПЕДИЦИЙН ТАЙЛАН. ЭХ
Зохиогч: А.В.Казакевич
Он: 1924
Гар бичмэл, 86 х, 21,5x36 см.



"ГАЛДАН БОШГОТЫН ЗАХИДАЛ"

Галдан Бошгот хааны Оросын эзэн хаанд бичсэн захидал.
Оросын Эртний улсын архив. Урт: 68 см, Өндөр: 41,4 см.



П.К.КОЗЛОВЫН УДИРДСАН МОНГОЛ-ТӨВӨДИЙН
СУДАЛГААНЫ ЭКСПЕДИЦИЙН ФОТО АЛЬБОМ.ЭХ. 1923-1926 он.



Персонал Монголо-Тибетской экспедиции (с гостем Сван-Гедином).